

**БОЛОВСРОЛЫН ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ ДЭМЖИХ ЖИЛ”-ИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
СҮҮЛИЙН ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ**

**Өлзийт сум**

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтод түвшин	Зарцуулах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийн хамт / сая төгрөг/	Хугацаа /сараар/	Хэрэгжилт	Хувь
1	2	3	4	5	6	7	8	
<b>1.Боловсролын салбарын багш ажилтан, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр</b>								
1	“Сайн багш-Сайн цэцэрлэг” аяныг зохион байгуулах, үр дүнг тооцох	Ур чадвар өссөн багшийн тоо	0	9	ОНТ 12,5	2-11 сард	1-5 жил ажиллаж байгаа багш нарын “Сайн хичээл” арга хэмжээнд СӨБ-ийн 1 багш оролцож ур чадвараа сайжруулсан. Отгонтэнгэр их сургуульд бүлгийн багшаар 2, туслах багшаар 1 багш нийт 3 багш шинээр суралцаж мэргэжлээ дээшлүүлж байна. Сургуулийн өмнөх боловсролын орчны стандартын үнэлгээнд амжилттай үнэлэгдсэн. Танхимаар суралцахгүй байгаа хүүхдүүдийн эцэг эх, асран хамгаалагчдад цахим хаягаар сургалтын арга барилаа сурталчилсан нь хамран сургалтаа нэмэгдүүлэх шинэлэг ажил болсон. Цэцэрлэгийн үйл ажиллагаанд дотоод хяналт, ёс зүйн зөвлөл хяналт тавин ажиллаж байна.	70%
		Үйл ажиллагааны чанар дээшилсэн цэцэрлэгийн тоо	0	3				
2	Физик, математикийн хичээлийн шинэ арга зүйг нэвтрүүлэх туршилтыг зохион байгуулах бэлтгэлийг хангах	Шинэ арга зүйд суралцсан багшийн тоо	0	30	УТ 4,0	2-6 сард	Физик, Хими, Математикийн хичээлд Документ камер, уян самбар, үелэх систем зэргийг хичээл практикийн зардлаас гарган сургалтын үйл ажиллагаанд хэрэглэж байна. Физикийн багш Б.Баярмаа Аймгийн Залуу багш нарын ур чадварын уралдаанд 5-р байранд шалгарсан..	100%
3	Залуу багш нарыг мэргэжил арга зүйгээр хангах, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх	Мэргэжлийн ур чадвар нэмэгдсэн залуу багшийн тоо өссөн дүнгээр	10		УТ 3,2	4-р сард	."Хүүхэд нэг бүрээ хөгжүүлдэг багш" багш нарын багшлах арга зүйг хөгжүүлэх сурлагын чанарыг сайжруулах зорилгоор "Зөвлөх багшийн үйлчилгээ" төсөл хэрэгжүүлэгч Ч.Нямаа 2 удаа ирж тус төсөлд	100%

				20			хамрагдаж буй багш нарын хичээлд 4 удаа сууж аргачлал, хүүхдийн дадал хэвшил дээр үнэлгээ өгсөн. Үүнд: 2022-11.01-02-ны хооронд нийт багш нарын үнэлгээний дундаж 42,49%-ийн гүйцэтгэлтэй байсан бол 2023-04-11-12-ны хооронд нийт багш нарын үнэлгээний дундаж 61,36% буюу 18,87%-иар ахицсан үзүүлэлттэй байна. Хүүхдийн ээлжит хичээлээр өөрт хэвшүүлсэн дадал хэвшил 64,46%-ийн гүйцэтгэлтэй үнэлэгдлээ. Мөн 3, 4-р ангид eduten, 5, 6-р ангид pearson цахим платформ хэрэгжиж байгаатай холбоотой мэдээлэл зүйн танхимд 12ш таблетыг шинээр авч сургалтад ашиглаж байна. Багш нар ажлын байрандаа тасралтгүй хөгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор багш нар онол арга зүйн цахим болон танхимын сургалтад 100% хамрагдаж байна. Отгонтэнгэр их сургуульд Цэцэрлэгийн бүлгийн багш мэргэжлээр 2 багш, туслах багш мэргэжлээр 1 багш суралцаж байна.	
4	Багш, удирдах ажилтныг гадаадад туршлага судлуулах	Гадаадад туршлага судалсан албан хаагчдын тоо өссөн дүнгээр	4	10	-	3-11 сард	2023 онд гадаадад туршлага судалсан албан хаагч байхгүй.	ҮБ
5	Байгууллагын менежмент, үр дүнг дээшлүүлэх чиглэлээр туршлага судлах, зөвлөн туслах ажлыг зохион байгуулах	Хамтран ажилласан сургууль, цэцэрлэгийн тоо Нэвтрүүлсэн арга туршлагын тоо	42 0	42 42	-	1-11 сард	Байгууллагын менежментийг боловсруулах, сайжруулах талаар ЖАЙКА төслийн сургалтад хамрагдаж, Мандал сургууль, НЕБ-ын 97-р суруультай хамтран ажиллаж өөрийн сургуулийн менежментийг боловсруулсан. Улаанбаатар хотод болсон сургуулийн захирлуудын 5 жилийн сургалтын үеэр 34 сургуулийн захирлуудад арга туршлага таниулж нэвтрүүлсэн. Мөн Баян-Өлгий аймгийн 10-р сургуулийн захирал Еркегүлд өөрийн хэрэгжүүлж байгаа “Сургуулийн менежмент”-ийн туршлага хуваалцан хамтран ажиллаж байна. Дэлхийн багш нарын 29, Монголын багш нарын 57 дахь өдрийг тохиолдуулан Зүүн бүсийн 6 сумдын цэцэрлэгийн багш, ажилчдын уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулж сургалтын менежмент, ур чадвар, арга туршлага хуваалцсан.	100%
<b>2.Сурагчдын хөгжил оролцоог нэмэгдүүлэх, сурлагын амжилтыг ахиулах чиглэлээр</b>								

6	Сурагчдын дунд олимпиад уралдаан зохион байгуулах	Олимпиад уралдааны тоо	2	8	ОНТ 8,0	3-4 сард	Аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан анги нийтийн 7 төрлийн төрөлжсөн олимпиадын 2-р шатанд 6 ангийн 120 сурагч, улсын төрөлжсөн олимпиадад 8 сурагч, 10 багш оролцсон. Химийн хичээлийн анги нийтийн олимпиад багш О.Шүрэнцэцэгийн бэлтгэсэн 6-р ангийн 18 сурагч амжилттай оролцож аймгийн 33 бүлгээс 2-р байранд шалгарсан амжилт гаргалаа.	100%
		Олимпиадад оролцсон сурагчдын тоо	650	850				
7	Дотуур байр, бүрэн дунд сургуулиудад явуулын сэтгэл зүйч ажиллуулах	Сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ авсан сурагчдын тоо	0	50	-	3-5 сард	ЭДЦС-ийн сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, хоол зүйчийг урьж багш, ажилчид, хүүхдүүдтэй уулзалт зохион байгууллаа. Дотуур байрны 36 хүүхдэд нийтийн уулзалт, мөн 6 хүүхдэд ганцаарчилсан уулзалт хийж сэтгэл зүйн зөвлөгөөг өгч хамтран ажиллалаа.	100%
8	Сурагчдын бүтээлч сэтгэлгээг дэмжсэн, бие даан ажиллах төсөлт ажлын бүлэг хичээллүүлж, үр дүнг тооцох	Бүлгийн тоо Сурагчдын тоо	0 0	60 600	ОНТ 20,0	3-10 сард	ЕБС-ийн СОУЗ, Өсвөрийн сэргийлэгч, Аврагч гэсэн 3 бүлгэмтэй. 3 бүлгэм оролцооны 27 сурагчтай. Бүлгэмүүд ажлын төлөвлөгөөний дагуу Анхны тусламж үзүүлэх үзүүлэлт Гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт Гал түймрээс урьдчилан сэргийлэх “Бид дээрэлхэхгүй” цахим аян “Мэргэжил сонголт” Crush box Сагсан бөмбөгийн 3x3 тэмцээн “Үе тэнгийн дээрэлхэлт” “Хүчирхийллийн эсрэг хүн байя” Цахим гэмт хэрэг Хорт зуршлын эсрэг зэрэг сургалтуудыг бүлгэм тус бүрийн сурагчид зохион байгуулж 1-9-р ангийн 174 сурагч хамрагдав. ЕБС-ийн хүүхдийн хөгжилд зориулсан 11 төрлийн дугуйлан хичээллэж 89 хүүхэд хамрагдаж байна. Урлагийн дугуйланд хичээллэсэн 55 сурагч сурч хөгжсөн авьяас чадвараа “Яргуй-2023” тайлан тоглолтоо хийж үр дүнгээ олон нийтэд таниулсан. УИХ-ын гишүүн Б.Саранчимэгийн хэрэгжүүлж буй “НОГООН БЭРС” хөтөлбөрийн хүрээнд: шатар, даамны дугуйлангийн сурагчдыг бүрэн шатаржуулсан.	100%

### 3.Сургалтын орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр

9	Цэцэрлэгийн гадна тоглоомын талбайд стандартад нийцсэн элсний талбай байгуулах	Элсний талбайтай болсон цэцэрлэгийн тоо	0	22	Хандив, тусламж	3-11 сард	Цэцэрлэгийн гадна тоглоомын талбайд элсний талбай байгуулав.	100%
10	Цэцэрлэгийн анги танхимыг хивс болон бусад эрүүл ахуйн шаардлага хангасан дэвсгэр чийг татахгүй дулаан хадгалдаг материалаар сайжруулах	Стандартад нийцсэн дэвсгэртэй болсон анги танхимын тоо	2	40	Хандив, тусламж	3-12 сард	Цэцэрлэгийн анги танхимын хивсийг сумын 2024 оны Орон нутгийн хөгжлийн сангаар хийхээр тусгагдсан.	50%
11	Багш нарын албан хэрэгцээнд ашиглах зориулалтаар нийлүүлэгдсэн, ашиглалтын шаардлага хангахгүй болсон компьютерыг шинэчлэх	Шинэчлэгдсэн компьютерын тоо	117	75	Хандив тусламж УТ 225,0	2-11 сард	ЕБСургууль, цэцэрлэгийн багш нарын компьютер шинэчлэх төслийг БШУЯ-наас хэрэгжүүлж байна. Сургуулийн нөхөн хангалтын зардлаар eduten, rearseon хөтөлбөрүүд хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай табилетын тоог 4-өөр нэмэгдүүллээ.	70%
12	Технологийн хичээлд юнимат багаж хэрэгслийг ашиглан цэцэрлэгт модон тоглоом хэрэглэгдэхүүнийг нэмэгдүүлэх	Хэрэглэгдэхүүний төрөл, тоо	0 0	5 100	-	2-11 сард	Технологийн кабинетыг 12,000,000 төгрөгийн өртөг бүхийн Юниматын сургалтын тоног төхөөрөмжөөр ханган ирээдүйн инженер бэлтгэж сурагчдыг сургах, хөгжүүлэх таатай орчинг бүрдүүлсэн. Баруун, зүүн бүсийн багш нарын “Хамтын ажиллагаа-Харилцаа үр дүн” зөвлөгөөнд Юниматын тоног төхөөрөмжөө танилцуулан үзэсгэлэн гаргаж, арга туршлагаа түгээн дэлгэрүүллээ. Цэцэрлэгт модон тоглоом хэрэглэгдэхүүнийг нийлүүлсэн.	100%
13	Сургуулийн мэдээлэл зүйн кабинетыг гэрчилгээжүүлж, цахим систем нэвтрүүлэх, үйл ажиллагааг сайжруулах	Гэрчилгээжсэн кабинетын тоо өссөн дүнгээр	4	12	-	2-11 сард	2022-2023 оны хичээлийн жилд Хөгжмийн кабинетыг 4,2 сая төгрөөр интернэт төхөөрөмж суурилуулж 60 Инч-ийн ухаалаг зурагт байршуулан цахим хичээл явуулах боломжийг бүрдүүлсэн. Мөн “Эх соёл-Их үндэс” хөтөлбөрийн хүрээнд 43,6 сая төгрөгийн техник төхөөрөмж нийлүүлэгдэж дуу бичлэгийн студи байгуулах боломж бүрдээд байна. Гэрчилгээжсэн кабинет 4 байна.	100%
14	Цэцэрлэгт анги бүлгүүд сойз ариутгагчтай болох	Ариутгагчийн тоо	0	50	ОНТ 50,0	3-11 сард	Боловсролын газраас бүх орон нутгийн цэцэрлэгт сойз ариутгагч өгөх төсөл хэрэгжиж байгаа боловч тус цэцэрлэгт одоогоор төсөл хэрэгжээгүй байна.	ҮБ
<b>4. Иргэд олон нийт төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах</b>								
15	Төрийн байгууллагуудтай хамтран “Багш өдөр” үйл	Үйл ажиллагааг явуулсан сургуулийн тоо	0 0	19 57	-	2-5 сард	Дэлхийн багш нарын 29, Монголын багш нарын 57 дахь баярын өдрийг тохиолдуулан боловсролын чанар хүртээмж, орчин нөхцөлийг сайжруулан үр дүнд хүрэх,	100%

	ажиллагааг зохион байгуулах	Оролцогчдын тоо					харилцан туршлага солилцож хамтын ажиллагаагаа бэхжүүлэх зорилгоор Зүүн бүсийн 8 сургуулийн “Хамтын ажиллагаа-Хариуцлага, үр дүн” уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулж 218 багш, ажилтан алба хаагчид оролцлоо. Зөвлөгөөний үеэр “Intinity Skills Academy”-ийн үүсгэн байгуулагч, сургагч багш Э.Өрнөхбилэг “Манлайллын суурь ур чадвар” сургалт хийсэн.	
16	Төрийн албан хаагчид, иргэдийг монгол бичгийн модуль сургалтад хамруулах	Модуль сургалтын тоо	2	3	-	1-11 сард	Төрийн албан хаагчдын Үндэсний бичгийн мэдлэг чадварыг ахиулах зорилгоор анхан болон дунд шатны үндэсний бичгийн сургалтыг 1 модуль буюу 24 цагаар 11 дүгээр сарын 01-нээс эхлэн зохион байгуулсан. Сургалтад нийт 46 албан хаагч хамрагдсан бөгөөд Анхан шатны сургалт -34 Дунд шатны сургалт-12 албан хаагч суралцаж, шалгалтаа амжилттай өгч бүгд 100 хувь “БАТЛАМЖ” гардан авсан.	100%
		Оролцогчдын тоо	1308	1962				
17	9,12 дугаар анги төгсөгчдөд мод тарих мэдлэг чадвар олгох, “Боловсрол төгөл” байгуулах	Тарьсан модны тоо	0	100	-	3-11 сард	9-р анги төгсөх 22 сурагчид суманд шинээр нэмэгдүүлсэн 1 га талбайд 99 мод суулгац тарьж усалгаа арчилгааг 7 хоног тутамд хийж байна.	100%
18	Политехник коллежийг түшиглэн сумдад дутагдалтай байгаа тогооч мэргэжлийн ажилчдыг бэлтгэж эхлэх	Тогоочоор суралцаж буй хүний тоо	0	15	-	2-12 сард	ЕБСургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төв зэрэг байгууллагад 5 тогооч ажиллаж байна. Тогооч нар бүгд мэргэжлийн үнэмлэхтэй.	100%
19	Тогооч, эцэг эхчүүдийн дунд үдийн хоолны цэс зохиох, хоолны өдөрлөг зохион байгуулах	Оролцогчдын тоо Шинээр гаргасан цэсний тоо	0 0	50 Цэс 5	ОНТ 10,0	9-11 сард	Сургуулийн эцэг эх, асран хамгаалагчдын дунд дотуур байрны тогооч нар хүүхдийн хоол, үдийн цайны өдөрлөг зохион байгуулж 10 нэр төрлийн үзэсгэлэн гаргаж 39 эцэг эхэд амталгаа хийж, эцэг эхчүүдтэй хоолны цэс зохиох туршлага солилцов. Мөн цэцэрлэгийн эцэг эхийн өглөөлөг өдөрлөгөөр 16 нэр төрлийн хоолны үзэсгэлэн гаргаж 30 эцэг эхэд амталгаа танилцуулав. “Хүүхдийн шимт тэжээлт хоол” уралдаанд 2 тогооч, хүүхдийн хоол, хүнсний шим тэжээллэг байдал, хангамж хүртээмж, сайн туршлага хуваалцах, манлайлалыг дэмжих “Хүүхдийн хоол” хэлэлцүүлэгт 6 тогооч оролцож шинээр 5 нэр төрлийн цэс зохиож туршлага хуримтлуулав.	100%
20	Жайка олон улсын байгууллагаас	Ширээний тоо сандлын тоо	0 0	50 200	ОНТ	3-11 сард	Төсөлд хамрагдаагүй	ҮБ

	хэрэгжүүлж буй Үдийн хоол үйлдвэрлэлийг дэмжиж төсөлд хамрагдсан сургуулийн үдийн хоолны танхимыг ширээ сандлаар хангах, орон нутгаас дэмжлэг үзүүлж хамтран ажиллах				20,0			
<b>5. Бүх нийтийн боловсролыг дэмжих, соён гэгээрүүлэх, сургалт нөлөөллийн чиглэлээр</b>								
21	“Цахим үндэстэн-E-Nation” зорилтын хүрээнд мэдээллийн технологийн чиг үүрэг бүхий албан хаагчдын мэдлэг чадварыг сайжруулах замаар иргэд, төрийн албан хаагчдын цахим ур чадвар /тоон бичиг үсэг-Digital literacy/-ийн боловсролыг дээшлүүлэх	Мэдээллийн технологийн чиг үүрэг бүхий албан хаагч болон цахим ур чадварыг дээшлүүлэхээр бэлтгэгдсэн сургагч багшийн тоо	0	16	ОНТ 10,0	1-11 сард	Гэр бүлд суурилсан бага насны хүүхдийн хөгжил, боловсролыг дэмжих “Таблеттай багш хөтөлбөр”-ийн хүрээнд аймагт зохион байгуулагдсан сургалтад цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн багш хамрагдаж “Гэр бүлийн” сургагч багшаар бэлтгэгдсэн.	70%
		Бүх нийтийн цахим ур чадвар, тоон бичиг үсэгтэн болох чиглэлээр зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоо	0	20	ОНТ 5,0	1-11 сард	“Малчдын зөвлөгөөн-2023” үеэр 300 гаруй иргэнд тоон гарын үсгийн талаар сургалт хийж 30 ширхэг гарын авлага тараасан. Мөн алслагдсан Буянт багт “Нэг цэгийн үйлчилгээ” үзүүлэн 53 иргэнд мэдээлэл өгч гарын авлага тараасан.	
		Цахим ур чадварын сургалтад хамрагдсан иргэдийн тоо	0	5000	ОНТ 5,0	1-11 сард	E-mongolia операторын мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтад мэдээллийн технологийн чиг үүрэг бүхий албан хаагчийг хамруулсан.	
22	“Амьдралын зөв дадал хэвшлийг төлөвшүүлэхэд иргэдийн оролцоо” сэдвийн дор календарчилсан төлөвлөгөөний дагуу сургалт, мэдээлэл, контент арга хэмжээг зохион байгуулах	Сургалт мэдээлэлд хамрагдсан иргэдийн тоо	3840	11000	УТ 28,5		Эрүүл мэндийн төв нь: ЕБС-ийн сургуулийн ахлах ангийн 46 сурагчид Электрон тамхины хор уршгийн талаар сургалт хийж гарын авлага тараасан. Сумын хоол үйлдвэрлэгч нар болон сургууль, цэцэрлэгийн 9 хоол зүйч, тогооч нарт “Эрүүл хоололт” сургалт хийж гарын авлага түгээсэн. Өлзийт сумын Эрүүл мэндийн төв цахим хаягт 4 төрлийн контент байршуулж олон нийтэд мэдээлэл түгээсэн. -Энэ жилдээ-Эрүүл жиндээ” аяны хүрээнд: Идэвхтэй хөдөлгөөн-эрүүл мэнд уриан дор 69 иргэнийг сургалтад хамруулсан. Үр дүнд 6 иргэн өглөө алхах, 2 иргэн зааланд идэвхтэй хөдөлгөөн хийж байна.	100%
		Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоо	179	220				

		Контентын тоо	2	15			Дугуй унах хөдөлгөөнд сургуулийн 59 хүүхэд, насанд хүрэгчид 9 байна. Шагайн спортоор 9 иргэн тогтмол хичээллэж байна. Танита аппаратаар 150 хүний биеийн жингийн индексийг тодорхойлсон.	
		Идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр хичээллэсэн иргэдийн тоо	371	2500				
23	“Уяхан замбуу тивийн наран” уртын дуучид, морин хуурчдын сургагч багшийг сургалтад хамруулах	Бэлтгэгдсэн сургагч багшийн тоо	62	68	ОНТ 5,1	1-11 сард	“Уяхан замбуу тивийн наран” уртын дуучид, морин хуурчдын 2 сургагч багш бэлтгэгдсэн.	100%
<b>Хэрэгжилтийн хувь: 100% - 16 70% - 3 50%-1</b>								<b>93%</b>

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ ХЯНАСАН  
 ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
 ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ ..... (Б.ОЮУНХАНД)

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ ТООЦСОН:  
 НИЙГМИЙН БОДЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН ..... (Х.АЛГИРМАА)